

ОРШИЛ

“Тод-Ундрага” ХХК нь Сэлэнгэ аймгийн Баянгол суманд орших 291.76 га бүхий MV-017573 тоот тусгай зөвшөөрөлтэй “Нэргүй хөндий” алтны шороон ордыг эзэмшдэг.

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа нутаг юм. Тус талбайн ард Бороо гоулд компанийн олборлолтын талбай залгаа оршдог.

Нэргүй хөндийн ордын дээд хэсгийг ашиглаж дууссан бөгөөд 2016 онд ордын доод хэсэгт үргэлжлүүлэн нарийвчилсан хайгуулын ажил явуулж ЭБМЗ-өөр нөөц батлуулан 2017 онд ТЭЗҮ батлуулсан. Уг ТЭЗҮ-ээр 5 жил ашиглахаар төлөвлөгдсөн.

Нэргүй хөндийн алтны ордод 2015 оноос олборлолтын ажлыг эхлүүлж, 2015-2022 онд олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд тухайн олборлолтоос үүссэн үүсмэл ордод 2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнг нэгтгэж, 2017 онд батлагдсан “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-д нийцүүлэн нөөцийг дахин тооцоолж ҮГА-ны даргын 2023 оны 06-р сарын 14-ны өдрийн н/34 тушаалаар 546,63 мян.м³ эфель, 74,67 кг алтны нөөц бүртгүүлсэн.

Нэргүй хөндийн алтны шороон ордын 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд В-1 блок болон үүсмэл ордын С-1/2, С-2/1, С-2/2 блокуудад үйл ажиллагаа явуулан үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор нийт 1,5 га талбай уурхайн олборлолтонд өртөж уурхайн олборлолтын талбайгаас 4,5 мян.м³ өнгөн хөрс, 327,7 мян.м³ үндсэн хөрс хуулан дунджаар 0,184 мг/м³ агуулгатай 145,718 мян.м³ элс олборлон баяжуулж, химийн цэврээр 24,471 кг алт олборлохоор тусгаж байна.

2024 онд 1.0 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийн ажил, 0,5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил, Тэрбум мод төслийн хүрээнд 5000 мод тарих, дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн БОАЖГ-аас санал авч Ерөө сумын Бугант 3 дугаар багт 5,0 га газар техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөж байна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр

“Нэргүй хөндий” алтны шороон орд төсөл

Төслийн зорилго, ач холбогдол

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар төсөл хэрэгжүүлэх 5 жилийн хугацаанд 270,87 мян.м3 элс угаан баяжуулж, 205,9 кг алт борлуулах ба тодорхой тооны хүмүүсийг ажлын байраар ханган, өөрийн компанийн болон улс, орон нутгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, Ашигт малтмалын тухай хуулийн 35.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглахад чиглэгдэнэ.

Төсөл хэрэгжүүлэгч

“Тод-Ундрага” ХХК, Захирал: Ч.Оюунгэрэл

Улсын бүртгэлийн дугаар: 9011009093

Регистрийн дугаар: 2872943

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Дунд гол, өөрийн байр, 201 тоот.

Утас: 99113446


Төслийн байршил

“Нэргүй хөндий” алтны шороон орд нь Сэлэнгэ аймгийн Баянгол суманд байрлах ба Улаанбаатар хотоос баруун хойш 126 км, Мандал сумын төв Зүүнхараагаас баруун урагш 24 км, Баянгол сумын төв Баруунхараагаас 19 км зайд оршдог. Тус MV-017573 талбай нь байр зүйн зургийн M-48-117 хавтгайд байрлана.

Хүснэгт 1. MV-017573 тусгай зөвшөөрөлтэй талбайн цэгийн солбицол

Дугаар	№	Уртраг			Өргөрөг			Талбай, га
		град	мин	сек	град	мин	сек	
MV-017573	1	106	09	49.97	48	44	05.87	291.76
	2	106	10	37.2	48	43	41.87	
	3	106	10	48.2	48	43	54.87	
	4	106	13	11.2	48	42	39.88	
	5	106	13	9.97	48	42	38.87	
	6	106	12	54.2	48	42	38.87	
	7	106	12	54.2	48	42	25.87	
	8	106	12	38.9	48	42	25.87	
	9	106	10	30.64	48	43	34.21	
	10	106	10	32.26	48	43	35.75	
	11	106	10	21.92	48	43	41.13	
	12	106	10	20.35	48	43	39.69	
	13	106	9	41.22	48	44	0.54	

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. MV-017573 талбайн байрзүйн зураг



Зураг 2. MV-017573 талбайн сансрын зураг

1.2. Уурхайн хүчин чадал

Нэргүй хөндийн алтны шороон ордын 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд В-1 блок болон үүсмэл ордын С-1/2, С-2/1, С-2/2 блокуудад үйл ажиллагаа явуулан үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор нийт 1,5 га талбай уурхайн олборлолтонд өртөж уурхайн олборлолтын талбайгаас 4,5 мян.м³ өнгөн хөрс, 327,7 мян.м³ үндсэн хөрс хуулан дунджаар 0,184 мг/м³ агуулгатай 145,718 мян.м³ элс олборлон баяжуулж, химийн цэврээр 24,471 кг алт олборлохоор тусгаж байна.

2024 оны ашиглалтын саруудад хийгдэх ажлууд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилийн төлөвлөгөө	2-р улирал				3-р улирал			4-р улирал	
			3	4	5	6	7	8	9	10	11
Хөрс хуулалт	мян. м ³	332.200		32.2	50	50	50	50	50	50.0	
Хүдэр олборлолт	мян. м ³	145.718	10	18.0	18.00	18.0	18.0	18.0	18.0	18.0	9.718
Урьд оны үлдэгдэл хүдэр	мян. м ³	0.0									
Хүдэр боловсруулалт	мян. м ³	145.718	10.0	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.00	18.0	9.718
Дундаж агуулга	г/м ³	2.5	1.041	0.205	0.193	0.199	0.181	0.174	0.175	0.197	0.163
Нийт бүтээгдэхүүн гаргалт	кг	0.0									
Бүтээгдэхүүн гаргалт-АЛТ	кг	26.859	1.446	3.687	3.472	3.589	3.254	3.128	3.15	3.546	1.587
Бүтээгдэхүүн гаргалт-МӨНГӨ	кг	2.1	0.116	0.295	0.278	0.287	0.26	0.25	0.252	0.284	0.127
Нийт бүтээгдэхүүн борлуулалт	кг	0.0									
Бүтээгдэхүүн дотоодод-АЛТ	кг	24.471	1.317	3.359	3.163	3.270	2.965	2.850	2.870	3.231	1.446
Бүтээгдэхүүн дотоодод-МӨНГӨ	кг	2.0	0.105	0.269	0.253	0.262	0.237	0.228	0.230	0.258	0.116

1.3. Уурхайн ашиглалтын систем

Төлөвлөгөөт онд “Нэргүй хөндий” үүсмэл ордын 2023 онд ашиглалт яваад үлдсэн хэсгээс эхлэн элс олборлолтын ажил хийгдэнэ. Үйл ажиллагааны дунд үеэс эхлэн В-1 блокын хөрс хуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд ашиглалтын ажлыг эхлэхдээ нийт блокын шимт хөрсийг карьерийн 2 тал руу бульдозероор түрж шимт хөрсний овоолго үүсгэнэ.

Хөрс хуулалтын ажлыг эхлэхийн өмнө үржил шимт хөрс буюу газрын гадаргаас ойролцоогоор 0.2-0.4 м орчим дундажаар 0.3 метр зузаантай хэсгийг бульдозероор түрж овоолж экскаватороор автосамосвалд ачиж олборлолтын талбайн гадна талд овоолго үүсгэнэ.

Энэ нь нөхөн сэргээлт хийх ажлын төгсгөлд үржил шимт хөрсөөр буцаан хучих нөхцлийг хангаж өгнө. Нэргүй хөндийн алтны уурхайн хувьд карьерийн гүн 41м

бөгөөд хөрсний чулуулаг нь хайрга, элс голдуу зөөлөн хөрстэй тул доголын налууугийн өнцгийг 55⁰ байхаар, бульдозроор хөрс хуулах үед хөрсний доголын налууугийн өнцөг 20-25⁰ байхаар тооцооллоо.

3.3 Уурхайн ажлын горим

Ордын хөрс хуулалт болон элс олборлолтын ажлыг хоногт 10 цагийн 2 ээлжээр, элс угаан баяжуулах ажлыг хоногт 10 цагийн 2 ээлжээр гүйцэтгэх бөгөөд долоо хоногт ажлын өдөр 7 байхаар тооцлоо.

Ажилбарын нэр	Нийт хоног	Үргэлжлэх хугацаа	
		эхлэх	дуусах
Жилийн хуанлийн өдөр	245	3/16/2024	11/15/2024
Баяр ёслолын хоног	5		
Цаг агаарын хүндрэлтэй хоног	30		
Ажиллах ажлын өдөр	210		
Уурхайн бэлтгэл ажил	20	3/16/2024	4/5/2024
Шимт хөрс хуулах	7	4/16/2024	4/17/2024
Хөрс хуулалтын хоног	60	3/20/2024	10/25/2024
Элс олборлолтын хоног	60	3/25/2024	11/5/2024
Элс угаах хоног	108	3/20/2024	11/15/2024
Нэг хоног дахь ээлжийн тоо	2 ээлж		
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	10 цаг		
Дотоод овоолгоор дүүргэлт хийх	60	3/16/2024	10/15/2024
Дотоод овоолгоор дүүргэлт хийсэн талбайг хэлбэржүүлэх	5	8/25/2024	9/1/2024
Хөрсний гадна овоолгын зарим хэсгийг хэлбэржүүлэх			
Шимт хөрсөөр хучих	3	8/25/2024	9/1/2024
Биологийн нөхөн сэргээлтийн ажил	3хоног	5-р сард 0,5 га талбайд олон наст ургамал тарина	

1.4. Усан хангамжын эх үүсвэр, усны хэрэглээ

Унд ахуй: БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 12-р хавсралтын дагуу дагуу 1 хүний хоногт хэрэглэх усны хэмжээг 150 л/хон/хүн-ээр тооцоолов. Уурхайд байнгын 60 хүн ажиллах тул хоногт 150л/хоног/хүн * 60 хүн = 9,0м³, сард 9м³х 30 = 270м³, жилд 245хон х 9м³= 2205 м³ ус хэрэглэнэ.

Хүснэгт 4. Унд, ахуйн усны хэрэглээ

Ашиглалтын жил	Ажилчдын тоо	Хоногт, м ³	Сард, м ³	Жилд, м ³	Ундрага, л/сек
2024	60	9,0	270	2205	0.07

Унд ахуйн хэрэгцээнд 2024 онд 2205м³ буюу 0.07 л/сек ус хэрэглэнэ.

Баяжуулалт: Нэргүй хөндийн алтны шороон ордын баяжуулалтанд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 2-р хавсралтын дагуу 1 м³ элс угаан баяжуулахад 4.0 м³ ус орохоор тооцоолов. 2024 онд 145,718 мян.м³ элс угаан баяжуулна.

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Баяжуулалтанд $145718 \text{ м}^3 * 4.0 \text{ м}^3 = 582872 \text{ м}^3$ ус ашиглана. Үүнээс $116574,4 \text{ м}^3$ цэвэр усыг нөхөн сэлбэлтээр ашиглах ба уурхайлалтын явцад шавхах усыг баяжуулах үйлдвэрийн цэвэр усны нуур луу хийж ажшиглана.

Ижил төстэй уурхайнуудад алтны шороон ордын баяжуулах үйлдвэрийн эргэлтээр ашиглах усны хэмжээг 80% гэж тооцоолдог байна. Иймд тус төслийн ТЭЗҮ-д тооцоолсны дагуу эргэлтээр ашиглах усны хэмжээг 80% гэж тооцлоо.

Тоос дарах: Дотоод тээвэрлэлт, хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт дарахад шаардлагатай усны хэрэглээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 13-р хавсралтын дагуу 1 м^2 талбайн тоосжилт дарахад 2 л ус зарцуулахаар тооцоолов. Жилд 1,0 га зам талбай услах ба хоногт 1 удаа, 1 жилд 50 хоногийн хугацаанд усалгаа хийнэ гэвэл хоногт $1 \text{ га} \times 20 \text{ м}^3/\text{га} \times 1 \text{ удаа} = 20.0 \text{ м}^3$ ус хэрэглэнэ.

Замын усалгаанд дунджаар 1.64 л/сек ус хэрэглэнэ.

Хүснэгт 5.Зам, талбайн усалгаа

Ашиглах жил	Жилд услах зам, га	1 удаагийн усалгаанд, м^3	1 хоногт	1 жилд	Ундрага, л/сек
2024	1,0	20	20	768	1.39

Тоосжилт дарах зам талбайн усалгаанд жилд дунджаар 768 м^3 , 1.39 л/сек ус хэрэглэхээр байна.

Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ:

Нөхөн сэргээлтэнд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 11-р хавсралтын дагуу олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг $4 \text{ л}/\text{м}^2$ нормоор услахаар тооцлоо.

2024 онд 0,5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийнэ. Үүнд $600,0 \text{ м}^3$ ус зарцуулна.

Хүснэгт 6. Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ

Ашиглалтын жил	Жилд нөхөн сэргээлт хийх талбай, га	1 удаагийн усалгаанд, м^3	1 сард, м^3	1 жилд, м^3	Ундрага, л/сек
2024	1,0	40,0	120	600	0.4

Биологийн нөхөн сэргээлтэнд 2024 онд 600.0 м^3 ус зарцуулна.

2024 оны нийт ус хэрэглээ:

Хүснэгт 7.2022 оны уурхайн нийт ус хэрэглээ

Баяжуулалт, м^3	Унд ахуй, м^3	Тоос дарах, м^3	Биологийн нөхөн сэргээлт, м^3	Нийт ус хэрэглээ, м^3
116,574	2205	768	600	120147

2024 онд уурхайд нийтдээ 120147 м^3 ус хэрэглэхээр байна. Уурхайд хамгийн ихдээ 8.05 л/сек усны эх үүсвэр шаардлагатай.

1.5. Цахилгаан хангамжийн үүсвэр

Нэргүй хөндийн алтны шороон орд нь дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт орших бөгөөд тус алтны уурхайгаас баруун зүгт 3 км зайд 10кВ-ийн өндөр хүчдэлийн шугам өнгөрдөг. Иймд уг 10кВ-ийн өндөр хүчдэлийн шугамаас уурхайн цахилгаан эрчим хүчний үндсэн үүсвэрээр авч тус уурхайн цахилгаан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангадаг.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлохдоо нөлөөллийн эерэг болон сөрөг эсэх; шууд, шууд бус нөлөөлөл; буцалттай, буцалтгүй эсэх; нөлөөллийн үргэлжлэх хугацаа, нөлөөллийн эрчим зэргийг тодорхойлов. Нөлөөлөлд өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлохдоо давхцуулан зураглах арга /overlay analysis/, магадлан жагсаах (checklist) арга зэргийг ашиглав.

Нөлөөллийг тодорхойлохдоо экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүд болон төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл гэсэн үндсэн 2 хэсэгт хувааж үзэв.

Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал

Төслийн үйл ажиллагаанаас экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг энэ хэсэгт хамруулсан.

Экосистемийн өөрчлөлт: Баяжуулалтын үйл ажиллагаанд газрын доорхи усыг ашигласнаар усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Олборлолтын ажлын технологи нь ил уурхайн аргаар ухаж ачих-гээвэрлэх гэсэн процессуудаас бүрдэнэ. Иймд геологийн тогтоцыг эвдэж өөрчлөх, газрын хэвлийн нөөц баялгийг ашиглах явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд нөлөөлөлд хамаарна. Ашиглалтын хүчин чадал бага боловч тухайн орон нутгийн байгаль-экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, ургамлан нөмрөг, гадаргын усны нөөцөд шууд сөргөөр нөлөөлж буй эдгээр нөлөөлөл нь дунд хугацааны дунд хүчтэй нөлөөлөлд хамрагдах бөгөөд ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Түүнчлэн тоос шороо дэгдэн бичил уур амьсгалын нөхцөл богино хугацаагаар бага зэрэг өөрчлөгдөж болох юм.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт: Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй юм. Иймд Монгол улсын Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд түүнийг сорчлон ашиглахыг хориглоно. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Тус уурхайн талбайд гаргасан гүний худгаас уурхайн хэрэгцээг хангах тул уурхайн талбайг бохирдуулах эрсдэлээс сэргийлэхгүй бол хөрс, улмаар газрын доорхи ус бохирдох эрсдэлтэй. Учир уурхайн хэрэглээ, шатах тослох материал, хог хаягдал зэрэгтэй холбоотойгоор гадаргын ус болон хөрс бохирдсон тохиолдолд газрын доорх усны чанарт өөрчлөлт орж болзошгүй бөгөөд энэ нөлөөлөл нь дунд хугацааны, бохирдсон гадаргын болон газрын доорхи уснаас мал, амьтан, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үр дагавар нь дунд зэрэг учир эрчим нь дунд зэрэг байна.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор: Байгалийн тогтоц буюу газрын гадаргын хэлбэршилд сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд 40 м гүн, 1,5 га талбай бүхий газрын хэвлийн олборлолтонд өртөж, хөрсний овоолго үүсэх бөгөөд энэ тухайн нутгийн байгалийн унаган дүр төрх, ландшафтыг хүчтэй өөрчлөлтөнд оруулах боловч нөхөн сэргээлтийг бүрэн хийснээр сөрөг нөлөөллийг багасгах, бууруулах боломжтой. Тус ордын нутаг орчим тусгай хамгаалалтай газар нутаг байхгүй.

Нийгэм, эдийн засаг: Ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулахаас гадна 80 хүнийг ажлын байраар хангах ба ажлын байр нэмэгдэх нь тэдний амьжиргаанд тус нэмэр болж буй сайн талтай юм. Эдгээр нь шууд бөгөөд богино хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

Хүснэгт 8. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй	Бага зэрэг	дунд зэрэг	Хүчтэй
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанарт өөрчлөлтгарах		-		-					-		
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон бусад барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-				-			-			-
Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас /хөрс хуулалт, олборлолт, овоолго, барилга байгууламж/ хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	-				-			-			-
Хөрс хуулалт, элс олборлолтоос геологийн тогтоцын өөрчлөлт	-				-			-		-	
Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх	-				-			-	-		
Уур амьсгалын/бичил/ өөрчлөлт											
2. Байгалийн нөөц, ашиглалт											
Газрын гадаргын нөөц баялаг	-					-		-	-		
Гадаргын усны нөөц багасах	-				-						-
Бэлчээр	-					-		-		-	
Эрдэс түүхий эдийн нөөц	-					-		-		-	
Эрчим хүчний нөөц											
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Шатах тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор газрын доорх ус бохирдох	-	-			-		-			-	
Гадаргын усны бохирдол		-			-					-	
Ил уурхай, хөрсний овоолго, зам зэрэг гадаргуугаас тоос босох, тээврийн хэрэгсэлийн хөдөлгүүр дэхь шаталтаас үүсэх хорт хий зэргээс агаар бохирдох	-				-		-			-	
Шатах тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор хөрс бохирдох	-				-		-			-	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олзвор											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-				-				-		
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-				-					-	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх											
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх											

Археологи, палентологийн олдворт нөлөөлөх											
5. Эдийн засаг, нийгмийн асуудал											
Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+					+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+					+		
Ажлын байр нэмэгдэх	+			+					+		
Уурхайн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+					+		
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-	-			-					-	
Нийт	18	4		4	13	3	3	7	8	9	3

“+” – эерэг нөлөөлөл, “-” – сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 18, шууд бус нөлөөлөл 4 байна. Нийт нөлөөллийн 8 - бага хүчтэй, 9 - дунд эрчимтэй, 3 - хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дунд хугацааны, дунд эрчимтэй нөлөөлөл байна.

Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

Нэргүй хөндийн уурхайн үйл ажиллагааны үед уг уурхайн байршил, техник-технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлах жагсаалтанд түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “+” гэж тэмдэглэв (хүснэгт 9).

Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл: Тус уурхай нь уулын хээрийн экосистем бүхий бүс нутагт байрлах тул алт олборлох технологийн бүхий л үе шатанд тоос шороо дэгдэхээс хамгаалах, олон салаа зам гаргах, хөрсний элэгдэл, эвдрэлийг ихэсгэхээс болгоомжлох, усны нөөцийг хэмнэх, усны хэрэглээг хамгийн бага байлгах, хөрс, усыг бохирдуулахаас сэргийлэх шаардлагатай. Шороон замаар зорчих явцад агаар орчинд тоос дэгдэх, хөрс элэгдэл, эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөтэй. Иймээс уурхайн дотоод замыг засч сайжруулах, хатуу эсвэл хайрган хучилттай болгож, цаг тухай бүрд нь засвар арчилгаа хийж байх хэрэгтэй. Мөн агаарт дэгдэж орчны агаар, хөрс, ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлнэ.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал: Нэргүй хөндийн алтны шороон орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг Монгол улсын Ашигт Малтмалын Газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар баталгаажуулан ил аргаар олборлож байгаа нь технологийн хувьд хамгийн оновчтой хувилбар гэж үзсэний баталгаа болох юм. Мөн БОННУ-ний тайлангийн эрдслийн үнэлгээний хэсэгт тодорхойлсон аюул ослын үнэлгээний үр дүн, Монгол улсын хууль эрхзүйн баримт бичгийн заалт бүрийг хангаж ажиллах хэрэгтэй.

Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал: Тус уурхайн олборлолтын үйл ажиллагаанд ШТМ ашиглана. Ахуйн хог хаягдлыг устгах, ариутгах зэрэг ажлыг тодорхой хуваарийн дагуу хийж, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж байх нь зүйтэй юм.

Хүснэгт 9. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
			бага	дунд	их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал					
1.1	Голын гольдролыг эвдэж өөрчлөх	+			
1.2	Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	+			
1.3	Ой модыг огтлох, гэмтээх	+			
1.4	Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдвор газрыг эвдэхэд хүрэх	+			
1.5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх			+	
1.6	Булаг, шандны усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх			+	
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал					
2.1.	Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, элсийг олборлох технологи, орчны хяналтанд сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой.			+	
2.2.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн		+		
2.3.	Элс олборлох үед болон уурхайгаас гарах грунтын уснаас хамгаалах, хорт бодис, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой		+		
2.4.	Эргэлтийн усан сангийн технологийн шийдэл		+		
2.5.	Тоосжилт дарахад ашиглах технологийн шийдэл		+		
2.6.	Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт бодис, тоосонцор гардаг эсэх	+			
2.7.	Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		+		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал					
3.1.	Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	+			
3.2.	Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний элэгдэл, эвдрэл		+		
3.3.	Үйлдвэрлэлийн осол аваарь гарах нөхцөл			+	
3.4.	Хортой нөхцөл үүсэх		+		
3.5.	Халдварт өвчин гарах нөхцөл		+		
4. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд /бодлогын чанартай асуудал/					
4.1.	Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг алдах	+			
4.2.	Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх		+		

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгах, нөхөн сэргээлтийг стандартын шаардлагад нийцүүлэн боломжит хамгийн их хэмжээгээр хийхэд онцгойлон анхаардаг.

Манай компани байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэж, энэхүү биелэлтийн тайланг бичих.
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ил тод байхыг эрмэлздэг бөгөөд нээлттэй хурал, хэлэлцүүлэг зохион байгуулна.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ус			
Унд ахуйн хэрэглээний худаг, технологийн ус, бохир ус зэргээс улирал бүр дээж авахуулж шинжлүүлэх	0,5	2023 оны үйл ажиллагаа эхлэхэд	- Усны тухай хууль - Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам А-156
Нийт, сая.төг	0,5		
Амьтан			
Шилийн сар, шонхор зэрэг махчин шувуудын үүр оромж, ангуучлах нутаг, тэдгээрийн идэш тэжээл бологч амьтдын элбэгшил, байршил нутаг зэргийг харгалзан хиймэл үүр барьж	0.3	Жил бүр, хавар	Амьтны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

өгөх			
Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжыг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээ авах	0.4	Хуурайшилт ихтэй үед	
Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих	-	Үйл ажиллагааны турш	
Нийт, сая.төг	0.7		
Агаарын чанар			
Салхи ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	-	Салхи, хуурайшилт ихтэй өдрүүдэд	MNS 4885:2007
Дотоод замыг салхи ихтэй, хуурайшилттай өдрүүдэд 2-4 л/м ² нормоор услаж байх,	Үйл ажиллагааны зардлаар		Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Нийт, сая.төг	0		
Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг			
Олборлолт явуулах, хөрс хуулах, овоолго хийх, баяжуулах үйлдвэр байгуулах, эргэлтийн усан сан барих зэргээр газар эвдэх бусад үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө өнгөн хөрсийг 0.3-0.5м зузаантайгаар хуулж овоолго байгуулан стандартын дагуу хадгалах	Уулын ажлын зардалд оруулан тооцно.	Жил бүр	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
Нийт, сая.төг	0		
НИЙТ, сая.төг	1,2		

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Нэргүй хөндий”-н ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008”, “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын шаардлагад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэнэ.

2024 онд 1,5 га талбай олборлолтод өртөнө. Уулын ажил дууссаны дараа олборлолтонд өртсөн талбайг дотоод овоолгоор түрж тэгшлэн хэлбэршүүлэх ба нөхөн сэргээлтийн хэмжээ, түүнд зарцуулагдах зардал, биологийн нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ болон зардлыг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 11. 2024 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн ажил	Талбай, га	Эзэлхүүн, мян.м³	Зарцуулах зардал,	Нийт зардал,сая.төг
-------------------------------	-------------------	------------------------------------	--------------------------	----------------------------

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

			сая.төг	
Техникийн нөхөн сэргээлт				
Дотоод овоолгоор нөхөн дүүргэх	1.0	300	0	5
Биологийн нөхөн сэргээлт				
Олборлолтонд өртсөн 1,0 га талбайд олон настын үр тарих,	0,5	-	10	0,5
Тэрбум мод аяны хүрээнд мод үржүүлгийн газар байгуулах	5000ш			4,5
Нийт зардал, сая.төг				10

Уурхайн техникийн нөхөн сэргээлтэд 5, биологийн нөхөн сэргээлтэнд 0,5 сая, Тэрбум мод төсөлд 4,5 сая төгрөг зарцуулна.

“Нэргүй хөндий”-н ордын нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ хөдөө аж ахуйн бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээнэ. Техникийн нөхөн сэргээлтийг хийхдээ ил уурхайн уланд эфель, гаалийн овоолгыг асгаж дээрээс нь гадаад хөрсний овоолгоор дүүргэн түрж тэгшлэн, орчны гадарга болон анхны төрх байдалд хамгийн ойр байхаар хэлбэршүүлнэ. Уурхайн зам талбай, баяжуулах үйлдвэр, усан сан, тосгон бусад нөлөөлөлд өртсөн бүх талбай, нүх суваг шуудууг түрж тэгшлэн шимт хөрсөөр хучин биологийн нөхөн сэргээлт хийнэ. Техникийн нөхөн сэргээлт дараах дарааллын дагуу хийгдэнэ.

- Уурхайлалт эхлэхийн өмнө турхайн жилд нөлөөлөлд /олборлолтонд өртөх хөрсний овоолгод дарагдах, тунаах нуурын зориулалтаар ухах/ өртөх талбайн шимт хөрсийг хуулах, шимт хөрсний овоолго үүсгэх
- Хөрсний гадаад болон дотоод овоолго үүсгэх
- Дотоод, гадаад овоолгоор ухагдсан сул орон зайг нөхөн дүүргэх
- Нөхөн дүүргэсэн болон гадаад овоолгын талбайг тэгшлэх, хэлбэршүүлэх, нягтаршуулах
- Эргэлтийн усан санг хуурайшуулах, хурдас чулуулгаар дүүргэх, тэгшилж хэлбэршүүлэх
- Бусад нөлөөлөлд өртсөн талбайг түрж тэгшлэх
- Тэгшлэлт, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр хучих
- Шимт хөрсөөр хучсан талбайд биологийн нөхөн сэргээлт хийх
- Уурхай хаагдсаны дараа хяналт шинжилгээ, хянан магадлагаа хийх зэрэг болно.

Шимт хөрсийг хадгалахдаа уурхайн ашиглах хэсгийн гадна талд шимт хөрсний овоолго үүсгэн “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу хадгална. Олборлолтонд өртөх талбайн шимт хөрсийг жил бүрт нь хуулах ба хуулсан шимт хөрсөө тухайн жилдээ нөхөн сэргээлтэнд ашиглана.

Уурхайн ухааш болон овоолгын ирмэгийн налууулалт хийх ажил нь байгаль хамгаалал, ойн аж ахуйн чиглэлийн нөхөн сэргээлтийн үед хийгдэнэ. Налуулах өнцөг нь байгаль хамгаалах чиглэлийн нөхөн сэргээлтийн үед 23⁰, ойн аж ахуйн нөхөн сэргээлтийн үед 12⁰-оос ихгүй байдаг. Хөрсний овоолго, уурхайн ухаашны хажуу налууулалтыг дээр заагдсан өнцгөөс бага болтол налуулж, хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээлт хийхийн тулд овоолгын гадаргууг долгиолог болгож, шаардлагатай болдог.

Биологийн нөхөн сэргээлт хийх зөвлөмж

2024 онд төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртсөн 0,5 га талбайд олон наст ургамлын үр тарихаас гадна 5000 ширхэг мод тарихаар төлөвлөсөн. Техникийн нөхөн сэргээлтийн үе шат бүрэн дуусч, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах зарчмаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ.

Шимт хөрсийг биологийн нөхөн сэргээлтэнд ашиглахы нөмнө хөрсний үржил шим, физик химийн үзүүлэлт, хөрсний механик бүрэлдэхүүн, хүнд металлуудын шинжилгээг хийж нөхөн сэргээлтэнд шууд хэрэглэхэд тохиромжтой эсэхийг зайлшгүй шинжилнэ. Хэрэв хучилт хийхэд тохиромжтой үзүүлэлтийг хангахгүй тохиолдолд хөрс сайржруулалт хийх, эрдэс болон шим бордоо хэрэглэх зэрэг арга хэмжээ авна.

Хэт нягтарсан талбайн хөрсийг хагалж, сийрэгжүүлэн ялзмагт хөрсөөр хучна. Хөрсийг сайжруулснаар агаар нэвтрэх боломж нэмэгдэж, ус бордооны шингэц сайжирна. Хөрсний шим тэжээлийг сайжруулахад бууц, хүлэр, чийгийн улаан хорхойгоор задалсан ялзмаг, шувууны сангас, өвс ургамлын үлдэгдэл, модны үртэс, ногоон бордоо зэрэг шим бордоог ашиглана.

Эвдэрсэн газрыг ургамалжуулах

Эвдэрсэн газрыг ургамалжуулахдаа “Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартыг баримтална. Биологийн нөхөн сэргээлтийг урьдчилан боловсруулсан төслийн дагуу мэргэжлийн байгууллага, ажилтаныг оролцуулан гүйцэтгэх шаардлагатайгаас гадна орон нутгийн иргэдийн оролцоог нөхөн сэргээлтийн ажилд аль болох өндөр байлгах, тэдгээр хүмүүсийн санал зөвлөмжийг тусгах нь зүйтэй.

Үрийн норм: Ашиглалтын дараа уурхайн талбайг бэлчээрийн зориулалтаар ургамалжуулах бөгөөд олборлолтын дараа нөхөн сэргээлтийн хэсэгт нэг болон олон настын үрийг 1x1 м²талбайд 10-20 гр-аар тооцож тарина. Үрийг 1-2 см-ийн гүнд суулгаж элсээр хучиж шүршүүрээр услана. Эхний 1 сард өдөр алгасч услах ба тарьснаас хойш 2-3 сарын дараа 3-4 хоног өнжөөд услана. Олон наст эдгээр ургамлын үрийг тарихын өмнө 200 мл усанд 100 гр үр хийж, 24 цагаас багагүй хугацаанд дэвтээх бөгөөд 6-8 цаг наранд сэврээж, соёолох чадварыг нь дээшлүүлнэ. Үрийг 2.0-2.5 см гүнд суулгана.

Тарих арга: Нөхөн сэргээлтийн талбайн хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд бордоо хэрэглэвэл үр дүн сайтай болдог. Нөхөн сэргээлтийн талбайд үрээр тариалахад гар арга, эсвэл техник ашиглана. Гараар тарьж байгаа тохиолдолд таримлын үрийг аль болох жигд тараан цацаж, үрлэсний дараа булдаж өгвөл зохистой. Техникээр тавьж байгаа тохиолдолд үр суулгах гүний хэмжээг 3 см-ээс хэтрүүлэхгүй, тариалалтын мөрийг орон нутгийн зонхилох салхины хөндлөн чиглэлд сонгоно. Ургамлыг үндэс, булцуу, мөчир зэрэг ургал эрхтнээр тарьж байгаа тохиолдолд нүх, далан шуудуу бэлтгэх аргыг хэрэглэх ба далан шуудууны чиглэлийг салхины хөндлөн, усны урсацын дагуу чиглэлд баривал зохистой.

Тарих хугацаа: Ургамал тариалах хугацааг агротехникийн нөхцөлөөс шалтгаалан сонгон авсан ургамлын төрөл зүйлийн онцлогт тохируулан төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль, цаг уурын нөхцөлтэй уялдуулан тогтоолоо. Ургамал тарих хугацааг “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын дагуу тогтооно. Тус уурхайн бүс нутагт усалгаатай нөхцөлд 5-р сарын 3 дахь 10 хоногт, усалгаагүй нөхцөлд 5-р сарын 1 дахь 10 хоногт тариална.

Тарих ургамал: Биологийн нөхөн сэргээлтэнд байгалийн бүс бүслүүрт нь тохируулан аль болох нутгийн унаган ургамал, модны төрөл зүйлийг сонгон тариалах нь зүйтэй. Тус уурхайн биологийн нөхөн сэргээлтэнд модлог ургамлаас бургас, шинэс, хайлаас,

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

нохойн хошуу, чацаргана, олон наст ургамлаас сибирь хялгана, гичгэнэ, улалж, царгас, согоовор, дагуур өлөнгө зэргийг тариалах нь тохиромжтой.


Мод тарих заавар. Тарихаар сонгон авсан мод, сөөгийг үрсэлгээний талбайд болон бортогоор үржүүлж байгаа тохиолдолд шууд шилжүүлэн суулгана. Суулгацыг тээвэрлэхдээ анхаарах зүйл бол үндсийг хатаахгүй байх явдал юм. 3-4 настай суулгацыг 50-70 ширхэгээр нь багцлан боогоод үндсийг хар шорооны нойтон зуурмагт дүрж бэхжүүлээд түүнийгээ нийлэг хальсаар 2-3 давхар боож хамгаалж тээвэрлэнэ. Модны суулгацыг тарихын өмнө багцнаас задлан үндсийг бүтнээр нь нойтон шороогоор булж түр хадгална. Модыг тарихдаа хавар IV.15-V.05-ны хооронд, намар IX.20-X.10-ны хооронд тарихад тохиромжтой.

Хүснэгт 12. Тарьмал модыг услах норм

№	Усалгааны норм	
1	4 дүгээр сарын 20-ноос 50 дугаар сарын 1	10 хоногт 1 удаа
2	5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 1	7 хоногт 1 удаа
3	6 дугаар сарын 15-наас 8 дугаар сарын 15	3-5 хоногт 1 удаа
4	8 дугаар сарын 15-наас 9 дугаар сарын 15	10-15 хоногт 1 удаа
5	Газар хөлдөхөөс өмнө 2-3 долоо хоногийн өмнө	Цэнэг усалгаа

Модны нүх ухаж бэлтгэх: Мод тарих талбайд модны нүхийг ухаж бэлтгэхдээ 0.7-0.8 метрийн голчтой, 0.5-0.6 метрийн гүнтэй нүхийг ухаж бэлтгэнэ. Ухсан нүхнээс гарсан хөрс, шорооны байдлыг харгалзан нүхний 50 хувьд нь үржил шимт хар шороон хөрс, хөх бууц 10 орчим кг-ыг нэмж хийн сайтар хутгаж тэгшилж орхино. Ухсан нүхнээс гарсан үржил шимгүй буюу хайргыг зөөж зайлуулан оронд нь хар шороон хөрснөөс бэлтгэн тавина.Энэ нь мод суулгах үед нэмэлт болон чигжихэд хэрэглэгдэнэ.Хуучин шороог болж өгвөл хэрэглэхгүй байх нь чухал.Учир нь хуучин бохир, үржил шимгүй, бүтцээ алдсан шороо, хөрсний үүрэг гүйцэтгэж шинэ суулгацны их, бага ямар нэг хэмжээгээр таслагдсан үндсийг цааш ургаж төлжихөд хангалттай шим тэжээл өгч чаддаггүй.Модны нүх ухсан газар нь хөрсний сүврэлт ихтэй /ус барих чадваргүй бүтэцтэй/ бол нүхний ёроолыг шар шавраар өнгөцхөн шавардаж өгч болох ба үндсэн хөрсийг бүрэн солих шаардлагатай.

Бут сөөгний нүх ухаж бэлтгэх: Таригдах төрөл бүрийн бут сөөгний нүх 50-60 см гүн, 40-50 см голчтой байна. Нүхэнд хийх шороо шим тэжээл сайтай хар шороон хөрс байх ба ухсан нүхнээс гарсан шороог ашиглаж болохоор бол /чулуу хайргагүй эсвэл хэт их шаварлаг юмуу дангаараа элс биш/түүн дээр 2-4 кг хөх бууц, 75-100 гр фосфорын бордоо нэмж сайтар хольж хийнэ. Ургамлан хашлага тарих шуудуу нь 50 см өргөн, 50 см гүнтэй байна. Шуудуунд хийх шорооны хэмжээ шуудууны 75 хувьтай тэнцэх хэмжээнд байна. Ухсан шуудуунаас гарсан шороог ашиглах боломжтой бол хар шороо, бууц, эрдэс бордоог дээрх хэмжээгээр хольж сайжруулсан хэлбэрээр ашиглаж болохоос гадна дан хар шороог ашиглаж болно. Ер нь олон жил талхлагдаж хөрсний үржил шим бүхий давхарга байхгүй болсон, хог болон бусад зүйлээр их бага ямар нэг хэмжээгээр бохирлогдсон байдаг учир шинээр хийх тохижилтонд хуучин хөрсийг ашиглахгүй байх нь зүйтэй юм. Нэгэнт бэлтгэж бэлэн болгосон нүх, шуудуугаа тарилт хийхийн урд өдөр 1-2 удаагийн давтамжаар ханатал ньусалж өгнө. Энэ нь хөрсний



Зураг 3. Мод тарих заавар

Ургамалжуулалт хийсэн талбайг арчилж хамгаалах

Биологийн нөхөн сэргээлтэнд олон наст ургамал тариалах ба нэг наст ургамлыг нөмрөглөх ургамлаар тарьна. Олон наст ургамлын онцлог нь эхний жилдээ үндсээ аван буталж ургасан бол дараа жилүүддээ ургалт нь жигдэрч, 2 ба 3 дахь жилээс үр боловсорч гүвэгдсэнээр өөрөө тэлэн ургах нөхцөл бүрддэг тул биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэснээс хойш 2-оос багагүй жилээр арчилж хамгаалах шаардлагатай. Төсөл хэрэгжих газар нь хур тунадас дундаж хэмжээнд ордог хэдий ч тухайн газарт зориудын усалгааг хийх нь зүйтэй.

3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

MV-017573 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэх шаардлагатай 1 хот айлын өвөлжөө байсан бөгөөд 2016 онд тус айлд өвөлжөө, өвөлжөөний газар худалдан авч өгч нөхөн төлбөрийг төлсөн тул цаашид нүүлгэн шилжүүлэх айл байхгүй.

4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйл, газрын гадаргад ил харагдах археологийн олдвор байхгүй. Гэсэн хэдий ч төслийн үйл ажиллагааны явцад газрын хэвлийгээс археологи, палеонтологийн дурсгал илэрч болзошгүй тул нийт ажилчид, жолооч нарт анхааруулга сануулга өгч, хэрвээ түүх, археологийн дурсгалт зүйл илэрвэл ажлаа нэн даруй зогсоож сумын удирдлага, цагдаагийн байгууллагад мэдэгдэн, эрдэм шинжилгээний байгууллагад хандах нь зүйтэй.

5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн хүрээнд олборлосон элсийг уурхайн талбайд скруберээр баяжуулна. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
----------------------------------	--	----------------------	--------------------------------

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Бүх ажилчдыг гал түймэр унтраах сургалтад хамруулах	0.3	Жил бүр, жилд 1 удаа
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	1,5	Уурхай эхлэхэд
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	0.1	Жил бүр шинэчлэх
Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах, - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах	-	Жил бүр
	Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулах	0,5	Тогтмол шалгах
Нийт зардал, мян.төг		2,4	

6. Дүйцүүлэн хамгаалал

Тайлант 2023 онд Сэлэнгэ аймгийн БОАЖГ-аас Ерөө сумын 3-р багийн нутаг Их Өлөнт нэртэй газарт 5,0 га уурхайлалтад өртөж эвдэрсэн газарт дүйцүүлэн хамгаалах ажил хийн орон нутагт хүлээлгэн өгсөн бөгөөд төлөвлөгөөт 2024 онд Сэлэнгэ аймгийн БОАЖГ-аас санал аван Бугант сумын нутагт нөхөн сэргээгдээгүй орхигдсон:

д/д	Солбилцол							
1	107.3678	49.40315	107	22	4.01	49	24	11.35
2	107.3694	49.40264	107	22	9.73	49	24	9.49
3	107.3675	49.40243	107	22	3.15	49	24	8.73
4	107.3692	49.40204	107	22	8.94	49	24	7.33
5	107.3679	49.40177	107	22	4.41	49	24	6.36
6	107.368	49.40216	107	22	4.9	49	24	7.79
7	107.3689	49.40079	107	22	8.02	49	24	2.83
8	107.368	49.40041	107	22	4.9	49	24	1.49
9	107.3689	49.40012	107	22	7.97	49	24	0.44
10	107.3684	49.39947	107	22	6.4	49	23	58.08
11	107.3693	49.39924	107	22	9.39	49	23	57.25
12	107.3686	49.39918	107	22	6.85	49	23	57.05
13	107.3687	49.39786	107	22	7.21	49	23	52.28
14	107.3697	49.39844	107	22	10.74	49	23	54.38

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Солбилцол бүхий 5,0 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөж байна.

7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг зайлуулахдаа дараахь дэс дарааллыг баримталж ажиллана.

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь арилгах, бууруулах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин ашиглах (хэрэв шаардлагатай бол сэргээн зассаны дараа)
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах

Хүснэгт 14. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах нь хог хаягдлыг дахин ялгах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	0,6	Жил бүр
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх	-	Тухай бүрт нь
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорхи ус бохирдуулах сөрөг нөлөөтэй	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах	1,0	Сард 1 удаа
	Дугуйн хаягдлыг хаягдал боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	-	Тухай бүрт нь
	Автомашинны сэлбэг, төмрийн хаягдлыг төмөр авах цэгт тушаах	1,5	Улиралд 1 удаа
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	0,3	Тухай бүрт нь
	Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах	-	Тухай бүрт нь
Ахуйн аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорхи ус бохирдож болзошгүй	Хэрэглэсэн батерей, принтерийн хөр гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	-	Тухай бүрт нь
	Уурхайгаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хаягдал тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	1,0	Тухай бүрт нь
Ажилчид санаатай болон санамсаргүйгээр ил задгай хог хаях	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	-	Жилд 1 удаа
Нийт зардал, мян.төг		4,4	

**8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг
хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтэнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтануудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх.	Нийгмийн хариуцлагын хүрээнд	1,0	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Багийн иргэдэд үйл ажиллагаа танилцуулах		1,0	Жилийн төгсгөлд	
Нийт, сая.төг		2,0		

9. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Хүснэгт 16. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

Байгаль орчны хүчин зүйл	Хяналтын үзүүлэлт	Байршил	Давтамж	Хууль, бодлого, стандарт	Хариуцах эзэн	Төсөв, мян.төг
1. Агаарын чанар						
Хөрс хуулах, элс олборлох, тээвэрлэх зэргээс тоос босч агаар бохирдох, Машин механизмын хөдөлгүүрээс хорт хий ялгарах	CO ₂ NO ₂ SO ₂ Тоос (нийт, PM10, PM2.5) Дуу чимээ, шуугиан, доргио	Ил уурхайн салхины чиглэлийн дээр, доор – тус бүр 1 цэг Засварын газар – 1 цэг Уурхайн тосгон - 1 цэг	Жилд 2 удаа	MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000 MNS 12.1.06:1988 MNS 12.4.005:1985 MNS 4585:2007	Мэргэжлийн байгууллагаар компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан хийлгэх	0,2
2. Хөрсөн бүрхэвч						
Шатах тослох материал, хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрсний механик бүтэц, хими физикийн шинж чанар, бохирдол,	Машины зогсоол – 1 цэг Хог хаягдлын цэг – 1 цэг ШТМ-ын агуулах – 1 цэг Тосгон - 1	Жилд 2 удаа	MNS 5850 : 2008	Байгаль орчны мэргэжилтэн	0,2

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	нефтийн бүтээгдэхүүн	цэг Шимт хөрсний овоолго – 1 цэг				
3. Ус						
Хөрсний бохирдлоор дамжин газрын доорхи ус бохирдох, уурхайн ус ашиглалтаас газрын доорхи усны түвшин буурах	Усны чанарын үндсэн үзүүлэлт болох анион, катион, хүнд металл, бактериологи, усны түвшин, ундрага	Уурхайн худаг	Жилд 2 удаа	MNS 900:2010. Ундны усны чанарын стандарт MNS 4943:2011. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус	Уурхайн БО-ны мэргэжилтэ н	0,6
Жилд зарцуулах зардал, мян.төг	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОНХАЖВ-нд тайлагнах шаардлагатай					1,0

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ. Тус хэлэлцүүлгийг 10-р сард зохион байгуулах ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд хэлэлцүүлгийн үр дүнг оруулна.

Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

№	Арга хэмжээ	Зардал, сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	1,2
2	Нөхөн сэргээлт	10
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	30
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх,соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,4
7	Хог,хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,4
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2,0
9	Орчны хяналт шинжилгээ	1,0
10	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	1,5
	Нийт зардал, мян.төг	50,0

Тус уурхай нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 50,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж байна.

УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтнүүдийн хувийн дугаар	
Дүгнэлт <ul style="list-style-type: none">Шийдвэрийн төсөлОлолт, амжилттай талДутагдалтай сул талШаардлага	

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

• Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, баганад мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.

• Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.

• 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Тод Ундрага” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011009093
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Ашигт малтмалын хайгуул, ашиглалт
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Баянгол дүүрэг 20-р хороо Ажилчдын гудамж, Өөрийн байр
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ч.Оюунгэрэл , 99113446,
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Т.Хатанцоож, 99140674, todundra.khatnaa@gmail.com
1.2	1. Төслийн нэр	“Нэргүй хөндий”

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

1. Төслийн харьяаллын байршил	Сэлэнгэ аймаг, Баянгол, Мандал сум
3. Төслийн ангилал а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт б. ил уурхай, далд уурхай, шороон орд в. баяжуулах үйлдвэр	А. Алт Б. Шороон орд В. Элс угаан баяжуулах цех
4. Төсөл эхэлсэн огноо	2015
5. Төсөл хэрэгжих хугацаа	10 жил
6. Уурхайн хаалт эхлэх огноо	2025
7. Хаалтын дараах зориулалт	бэлчээр
8. ТЭЗҮ баталсан огноо	2017
9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ	173,1 кг
10. Ажилчдын тоо	180
11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	Хөрс хуулалт, олборлолт, тээвэрлэлт, борлуулалт
12. Тухайн төсөлд хамрах дэд бүтэц • замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл; • шатахуун түгээгүүрийн тоо • шатахуун агуулахын агууламжийн хэмжээ • тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	 • Урт-1,0км, угаах төхөөрөмж-карьер • шатахуун түгээгүүрийн тоо -1 • шатахуун агуулахын агууламжийн хэмжээ – 200м3

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.

- Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд дугаар, огноог оруулах

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

• Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах баганад хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл		Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай		Ашиглалт /алт/ MV-017573 2032-07-10 291,76 га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа		Химийн бодис ашиглахгүй
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт		Хамааралгүй
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар		01804009
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		2017 БОАЖЯ
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд		2017 БОАЖЯ
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо		-
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо		2023-02-10
	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах		Маягтуудыг хавсаргасан болно
	10. Нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт /га-аар/	Тайлант онд гүйцэтгэсэн
Төлөвлөгөөт онд гүйцэтгэсэн			1,0
Биологийн нөхөн сэргээлтийн талбай /га-аар/		Тайлант онд гүйцэтгэсэн	0,1
		Төлөвлөгөөт онд гүйцэтгэсэн	1,0

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	11.ТХГН-ын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах	Давхцалгүй
--	--	------------

**ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2019 оны дүгээр сарын -ны өдрийн тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтад тусгагдсаныг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсаны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/
- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр,	Химийн бодис ашиглахгүй

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	хэмжээ /хэмжих нэгж/	
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 3. -Урьдчилан сэргийлэх арга хэмжээ -Эрсдлийн үед авах арга хэмжээ -Учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ -Хохирол нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	Хамааралгүй
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	1. Дизель түлшний агуулахтай 2. Ашиглахгүй
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал	290m3 10.0тн 10тн
	2.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	950,0 мян.төг

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

- Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	50000.0 мян.төг
	2. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	1200.0 мян.төг
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2400.0 мян.төг
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	22500.0 мян.төг

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	15000.0 мян.төг
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	1500.0 мян.төг
7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	2000,0 мян.төг
8. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	0,0 мян.төг
9. Хог хаягдал	4400,0 мян.төг
10. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1000,0 мян.төг

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг байгаль орчны мэдээллийн санд оруулна.

- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	
	Хог хаягдлын цэгийн байршил	
	Аюултай хог хаяглын агуулахын байршил	
	Хаягдлын далан	
	Химийн бодисын агуулахын байршил	
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	
	Хяналтын цэгийн байршил	
	Тухайн жилд хуулах хөрс	
	Гадаад, дотоод овоолго	
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	
	Гүний худгийн байршил	
	Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил	

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх баганад “**тодорхойлсон**”, “**тодорхойлоогүй**” “**хамааралгүй**” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсо н эсэх	Дүгнэлт
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	Тооцсон	Тооцсон	Тооцсон	Тооцсон	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	Тооцсон	Тооцсон	Тооцсон	Тооцсон	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчныг хуваах	Ургамалд үзүүлэх нөлөөг тооцсон, амьтанд үзүүлэх нөлөөллийг	Тооцсон	Тооцсон	Тооцсон	

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

- амьдрах орчныг доройтуулах - амьдрах орчныг хомсдуулах - нөөцийг бууруулах	тооцоолоогүй				
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	Тооцсон	Тооцсон	Тооцсон	Тооцсон	
6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс - Хамгаалах - Нүүлгэн шилжүүлэх	Тооцсон	тодорхойлсон	хамааралгүй	хамааралгүй	

**ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” баганад байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх.
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, баганад байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**тийм**”, “**үгүй**” хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн “Г” баганад байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтнүүд “**хангалттай**” “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ				
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн/ га эзлэхүүн - биологийн /га				
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ				

**Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Нэргүй хөндий” алтны шороон ордын
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

7.5.	7.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ				
7.6.	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ				
7.7.	Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ				

**НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” баганад байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв
8.1. Хөрс	2	Олборлолт орчмоос, уурхайн зам, хог хаягдлын цэг, нөхөн сэргээсэн талбай тус бүрээс	Хөрсний химийн шинжилгээ, хүнд металлын шинжилгээ, жилд 2 удаа	200.0
8.2. Ус	2	Ундны усны худаг болон технологийн уснаас тус бүр дууж авна,	Усны ерөнхий шинжилгээ хүнд металлын шинжилгээ Жилд 2 удаа	600,0
8.3. Агаар	2	Ажилчдын тосгон, машины эргэлтийн хэсэг олборлолт орчмоос	Агаарын ерөнхий шинжилгээний үзүүлэлтийн хамт тооцоход	200.0